

Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ

ЖИЛИЙН ТАЙЛАН

2019



МЭНДЧИЛГЭЭ

Үндэсний давхар даатгал ХК нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, олон улсын стандартыг хангасан давхар даатгалын хамгаалалтыг Монгол Улсад нутагшуулж, даатгалын салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, санхүүгийн зах зээлийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Стратеги зорилтын хүрээнд манай компани нь эдийн засгийн бүхий л салбар тэр дундаа уул уурхайн салбарт зориулсан бизнесийн болзошгүй эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцоог бий болгохоор ажиллаж байна.

Азийн томоохон давхар даатгагч болох Хятад Улсын Чайна Ре /China Re/, БНСУ-ын Кореан Ре /Korean Re/, Япон Улсын Тоа Ре /Toa Re/, Малайз Улсын Малайжиан Ре /Malaysian Re/ зэрэг 14 орны давхар даатгагчид багтдаг Азийн давхар даатгалын холбооны гишүүн байгууллага боллоо. Ингэснээр олон улсын томоохон давхар даатгагчдаас туршлага судлах, хамтран ажиллах боломжийг нээснээр бизнесийн цар хүрээгээ улам өргөжүүлэх боломжтой болж байна.

Даатгалын зах зээл улам бүр хүрээгээ тэлж, даатгалын хэрэгцээ өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж, хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй бизнесийн

Компанийн дүрмийн сангийн хөрөнгийг 5 тэрбум төгрөгөөр, Алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийг 4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, өөрийн багцыг хамгаалах олон улсын анхны трити гэрээг байгууллаа.

орчинд бид харилцагч бүрт тохирсон бүх төрлийн эрсдэлийг хамгаалах давхар даатгалын үйлчилгээг үзүүлж, даатгалын салбарын өсөлт хөгжлийг дэмжих зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Бидний тавьсан зорилгыг дэмжиж, үнэтэй туршлагаасаа харамгүй хуваалцдаг дотоод, гадаадын түншүүд, төр болон хувийн хэвшлийн хамтран ажиллагч байгууллагууд баялаг бүтээгч харилцагчиддаа талархаж байгаагаа илэрхийлье.

Та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ЭНХТАЙВАН

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Үндэсний давхар даатгал ХК нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, валютын гадагшлах урсгалыг бууруулах, олон улсын стандартад нийцсэн давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор 2014 онд байгуулагдсан төрийн өмчит хувьцаат компани юм. Бид өнгөрсөн хугацаанд олон улсын стандартад нийцсэн давхар

даатгалын үйлчилгээг үзүүлэн ажиллахын зэрэгцээ А.М Бэст агентлагийн /A.M Best/ “АА-” болон “А-” үнэлгээтэй дэлхийн шилдэг компаниуд болох SCOR /SCOR/, Ханновер Ре /Hannover Re/, Жи Ай Си Ре /GIC Re/, Тайпинг Ре /Taiping Re/ давхар даатгалын компаниудтай хамтран ажиллаж байна.

АЛСЫН ХАРАА

Бид үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй найдвартай байдлыг ханган давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, даатгалын салбарын өсөлт хөгжлийг дэмжинэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО


Бид Монгол Улсын даатгалын зах зээлийг олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээгээр хангаж, даатгалын салбарын эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг дэмжинэ.





КОМПАНИЙН БҮТЭЦ

Үндэсний давхар даатгал ХК нь Андеррайтингийн газар, Бизнес хөгжил, төслийн газар, Комплаенс, нөхөн төлбөрийн газар, Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар, Захиргаа, удирдлагын газар гэсэн 5 газар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

С.Наранцогт

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга

П.Дорждагва

Сангийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга

Ц.Болорчулуун

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

А.Дэмбэрэл

Үндэсний статистикийн хорооны Статистикийн эрдэм шинжилгээ, арга зүйн газрын дарга

П.Эрдэнэбаатар

Монголын даатгалын холбооны удирдах зөвлөлийн дарга

Д.Насанжаргал

Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны удирдах зөвлөлийн гишүүн

Б.Шаравсамбуу

Хараат бус гишүүн

Ц.Түмэнхишиг

Хараат бус гишүүн

Я.Батханд

Хараат бус гишүүн

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тайлант онд компанийн хөрөнгө өмнөх оноос **8.85** хувь буюу **4 тэрбум 718 сая** төгрөгөөр өсч **53.3 тэрбум** төгрөгт хүрсэн нь Монгол Улсын даатгалын салбарын 15 хувийг эзэлж, хөрөнгийн хэмжээгээрээ тэргүүлсэн үзүүлэлттэй байна. Мөн Алдагдлаас хамгаалах нөөц санг 4.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 19.0 тэрбум төгрөгт хүргэсэн бөгөөд

ингэснээр компанийн нийт нөөц сан **24 тэрбум 827 сая** төгрөгт хүрсэн нь тус компани их хэмжээний эрсдэлийг даах чадвартай боллоо.

Даатгалын хураамжийн орлого өнгөрсөн жилээс 59 хувь буюу 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж **2 тэрбум 740 сая** төгрөг боллоо.


ЦЭВЭР АШИГ



НИЙТ ХӨРӨНГӨ




ДААТГАЛЫН ХУРААМЖ



■ Нийт хураамж ■ Давхар даатгалын хураамж

НИЙТ НӨӨЦ САН

Тэрбум төгрөг



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



Компанийн нэрийг Үндэсний давхар даатгал ХК болгон өөрчлөв.



Азийн давхар даатгагчдын холбоонд гишүүн байгууллагаар элсэв.



Форбес Монголиа сэтгүүлийн шалгаруулалтаар Монголын даатгалын “Шилдэг 10 компани”-ийн нэгээр тодорлоо.



Дүрмийн сангийн хөрөнгийг 5.0 тэрбум төгрөгөөр, Алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийг 4.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ.



“Практикал даатгал” ХХК, “Мөнх даатгал” ХХК-тай дотоодын трити давхар даатгалын гэрээг Монгол Улсад анх удаа байгуулав.



Малын индексжүүлсэн даатгалд 32,337 малчин хамрагдаж, 3 тэрбум 845 сая төгрөгийн хураамж төвлөрүүлэв.



Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалд 5 аж ахуйн нэгжийн 781 га талбайд тариалсан үрийн буудайг даатгалаа.



Олон улсын давхар даатгалын багц гэрээг SCOR /SCOR/, Ханновер Ре /Hannover Re/, Жи Ай Си Ре /GIC Re/, Тайпинг Ре /Taiping Re/ зэрэг давхар даатгалын компаниудтай амжилттай байгуулав.



Шинэ 9 бүтээгдэхүүн нэвтрүүлж, өмнөх жилийн даатгалын хураамжийн үзүүлэлтийг 59 хувиар давуулан биелүүллээ.


БОРЛУУЛАЛТЫН ҮР ДҮН

Малын индексжүүлсэн даатгал


Үндэсний давхар даатгал ХК-ийн тав дахь жилийн МИД-ын борлуулалтын улирал 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр орон даяар эхэлж 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд оролцогч даатгагчид болох Ард даатгал ХК, Бодь даатгал ХХК, Монгол даатгал ХК, Монре даатгал ХХК, МИГ даатгал

ХХК, Номин даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК, Хаан даатгал ХХК компаниуд оролцон Хаан болон Төрийн банкаар дамжуулан нийт **32,337** малчин өрхийн малыг даатгалд хамрууллаа.

МИД-д даатгуулсан таван хошуу малын эзлэх хувь



МИД-ын хамрагдалт, даатгалын хураамжийн орлого /тэрбум төгрөг/



Малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнд хамрагдсан малчин өрхийн тоо, хураамжийн орлогыг 2006 оноос хойш үзэхэд давхардсан дүнгээр нийт **202 мянга орчим малчин өрх** даатгалд хамрагдсан байна.

Газар тариалангийн даатгал

Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын борлуулалтад Ард даатгал ХК, Бодь даатгал ХХК оролцож **620 сая** төгрөгний үнэлгээ бүхий 782.1 га талбайд тариалсан үрийн болон таваарын улаан буудайг даатган ажиллалаа.



Бусад даатгалын хүрээнд

Даатгалын хэлбэр	Хариуцлагын хэмжээ /мян.төгрөг/	Хураамж /мян.төгрөг/
Мал амьтны даатгал	108,005,357.28	1,613,303.54
Газар тариалангийн даатгал	557,591.14	29,561.48
Хөрөнгийн даатгал	107,627,905.75	263,853.92
Хариуцлагын даатгал	13,122,672.27	72,294.00
Ачаа тээврийн даатгал	449,488.70	12,495.51
Барилга угсралтын даатгал	347,569.05	14,236.91
Гэнэтийн ослын даатгал	1,383,766.25	580.00
Агаарын хөлгийн их биеийн даатгал	9,419,132.84	22,174.16
Агаарын хөлгийн хариуцлагын даатгал	8,236,132.75	46,302.62
Санхүүгийн даатгал	128,027.04	61.35
НИЙТ	249,277,643.07	2,074,863.49

НӨХӨН ТӨЛБӨР

Малын индексжүүлсэн даатгал

Малын индексжүүлсэн даатгалд 2018 онд даатгуулсан 33,718 малчин өрхөөс Улаанбаатар хотын Багахангай дүүрэг, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 31 сумын 3005 малчин өрхөд **323 сая төгрөгийн** нөхөн төлбөрийг Хамтын эрсдэлийн сангаас олголоо.

Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгал

Бодь даатгал ХХК-тай хамтран байгуулсан Макс Агро ХХК-ийн сүүний чиглэлийн Холштейн үүлдрийн үхрийн даатгалд нийт 11 даатгалын тохиолдол гарч гэрээнд заасан нөхөн төлбөр олгосон.

ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацитай хамтран уул уурхайн бус салбарын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилгоор Экспортыг дэмжих төслийг хэрэгжүүлж

байгаа бөгөөд “Экспортын шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх” нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэгч байгууллагаар Үндэсний давхар даатгал ХК сонгогдсон. Уг төслийн хүрээнд хоёр бүтээгдэхүүнийг боловсруулан зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж байна.



Эргэлтийн хөрөнгийн даатгал

Экспортлогч эргэлтийн хөрөнгийн даатгалын гэрээг барьцаалан банкнаас эргэлтийн хөрөнгийн зээл авах бөгөөд экспортлогч буюу зээлдэгч зээлээ төлөхгүй байх эрсдэлээс банк болон бусад санхүүгийн байгууллагыг хамгаална.

Даатгах эрсдэлүүд

Экспортлогч санхүүгийн байгууллагаас авсан зээл, зээлийн хүүг төлж чадахгүй байх

Нийлүүлэгчийн зээлийн даатгал

Экспортын гэрээний дагуу төлбөр хийгдэхгүй байх эсвэл гэрээний гүйцэтгэл, цуцлалт зэргээс үүдэн гүйцэтгэлийн зардлыг нөхөж чадахгүй байх эрсдэлээс экспортлогчийг хамгаална.

Даатгах эрсдэлүүд

- Арилжааны эрсдэл /Худалдан авагч түр төлбөрийн чадваргүй болох, худалдан авагч дампуурах, төлбөрийн удаашрал/
- Улс төрийн эрсдэл /Валютын ханшийн үл хөрвөх байдал, экспорт импортын лиценз цуцлах, дайн, иргэний бослого, үймээн самуун.../

ДАВХАР ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД



Ачаа тээвэр



Мэргэжлийн хариуцлага



Барилга угсралт



Ажиллагсдын
гэнэтийн осол



Хүнд машин механизм



Гэрээний хариуцлага



Эд хөрөнгө



Нефть, газрын тос



Олон нийтийн өмнө
хүлээх хариуцлага



Ажил олгогчийн
хариуцлага



Ерөнхий хариуцлага



Бүтээгдэхүүний
хариуцлага



Удирдах албан
тушаалтны хариуцлага



Бизнес тасалдал



Бараа материалын
үлдэгдэл



Ил уул уурхай

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- МИД-ын эрсдэлийн дунд түвшинд олон улсын давхар даатгалын СКОР /SCOR/ компанитай алдагдал зогсоох давхар даатгалын гэрээ байгуулж, хамтран ажиллав.



- Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалд даатгасан эрсдэлийн 25 хувийг дотооддоо даатгаж, үлдсэн 75 хувийг СКОР /SCOR/ компанид даатгуулж хувь оролцооны гэрээ байгуулан ажиллалаа.

- Азийн томоохон орнууд болох Хятад, Солонгос, Энэтхэг, Тайван, Сингапур, Малайз, Хонг Конг зэрэг Азийн нэр хүнд бүхий 14 орон багтдаг Азийн давхар даатгалын холбооны дээд хэмжээний уулзалт 2019 оны 10 дугаар сарын 9-11-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, тус чуулганд компанийн удирдлагууд оролцсон бөгөөд уг уулзалтын үеэр тус компани Азийн давхар даатгалын холбоонд гишүүнээр элссэн.



- Их Британийн Засгийн газрын Сансрын агентлагаас санхүүжилттэй Сибелиус /Sibelius/ төслийн хүрээнд орчин үеийн хиймэл дагуулаас авсан мэдээллүүдийг ашиглаж, МИД-ын бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, хиймэл дагуулын мэдээлэлд суурилсан

даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулж, малчдын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлж, санхүүгийн эрсдэлээс хамгаалан, малчдын амьжиргааг сайжруулах зорилгоор хамтран ажиллаж байна.



- Олон улсын давхар даатгалын брокер ЖиБи Бода /JB BODA & CO PTE Ltd/ давхар даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.

- Санхүүгийн зохицуулах хороо, ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), Хүртээмжтэй даатгалын асуудлаарх Азийн орнуудын мэдлэг туршлага солилцох сүлжээ (MEFIN)-тэй хамтран зохион байгуулж буй “Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн даатгал” сэдэвт төр, хувийн хэвшлийн олон улсын зөвлөлдөх ээлжит VII уулзалтад оролцлоо.

- Олон улсын давхар даатгалын трити гэрээг СКОР /SCOR/, Ханновер Ре /Hannover Re/, Жи Ай Си Ре /GIC Re/, Тайпинг Ре /Taiping Re/ олон улсын давхар даатгалын компаниудтай амжилттай байгуулав.

ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

“Үндэсний Давхар Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

ДҮГНЭЛТ

Бид “Үндэсний Давхар Даатгал” ХК (цаашид “компани” гэх)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид “хураангуй санхүүгийн тайлан” гэх) 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартаар шаардсан бүх тодруулгыг иж бүрэн агуулаагүй тул “Үндэсний давхар даатгал” ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно. Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БА ТҮҮНД ӨГСӨН БИДНИЙ ДҮГНЭЛТ

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн.

УДИРДЛАГА БОЛОН ЗАСАГЛАХ ЭРХ МЭДЭЛ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

АУДИТОРЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын Аудитын тухай хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК

Б. ОСОРГАРАВ
Удирдах партнер

Н. ЭРДЭНЭЦОГ
Гэрээт ажлын партнер

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	2019 мян.төгрөг	2018 мян.төгрөг
ХӨРӨНГӨ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,263,848	664,259
Даатгалын авлага	80,408	14,830
Урьдчилж төлсөн зардал болон бусад авлага	288,551	45,498
Давхар даатгалын хойшлогдсон хураамж	1,039,748	242,017
Хөрөнгө оруулалт	49,824,266	46,750,931
Үндсэн хөрөнгө	544,691	517,197
Биет бус хөрөнгө	287,132	375,474
Нийт хөрөнгө	53,328,644	48,610,206
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Даатгалын өглөг	386,946	318,103
Татварын өглөг	1,158,864	151,894
Бусад санхүүгийн бус өр төлбөр	371,285	72,196
Орлогд тооцоогүй хураамжийн нөөц	926,610	694,482
Хамтын эрсдэлийн сан	1,927,536	1,648,163
Эрсдэлээс хамгаалах сан	3,900,151	3,564,217
Нийт өр төлбөр	8,671,392	6,449,055
ЭЗДИЙН ӨМЧ		
Эзэмшигчдийн өмч	20,000,000	15,000,000
Эздийн өмчийн бусад хэсэг	489,264	489,264
Алдагдлаас хамгаалах сан	19,000,000	15,000,000
Хуримтлагдсан ашиг	5,167,988	11,671,887
	44,657,252	42,161,151
Нийт өмч ба өр төлбөр	53,328,644	48,610,206

ОРЛОГЫН ТАЙЛАН

	2019 мян.төгрөг	2018 мян.төгрөг
Даатгалын хураамжийн нийт орлого	2,074,863	1,738,278
Даатгалын хураамжийн буцаалт	-	(17,530)
Давхар даатгалын хураамжийн зардал	(1,707,969)	(825,298)
Даатгалын хураамжийн цэвэр орлого	366,894	895,450
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	(232,127)	(234,265)
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	797,730	36,824
Орлогод тооцсон хураамж	932,497	698,009
Нийт нөхөн төлбөрийн зардал	(18,450)	(521,939)
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	-	442,964
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	(335,934)	(293,521)
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	(354,384)	(372,496)
Хөрөнгө оруулалтын орлого	6,065,077	6,183,779
Бусад даатгалын хураамжийн бус орлого	269,790	314,305
Ерөнхий ба удирдлагын зардал	(2,510,879)	(1,987,955)
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(294,160)	(172,879)
Татвар төлөхийн өмнөх ашиг	4,107,941	4,662,763
Орлогын татварын зардал	(611,840)	(605,807)
Татварын дараах цэвэр ашиг	3,496,101	4,056,956

ГАДААД ТҮНШҮҮД:

SCOR

Swiss Re

SIBELIUS

berneunion

hannover re[®]



ДОТООД ТҮНШҮҮД:



Улаанбаатар хот-14251, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, 5-р хороолол, 10Б байр, Бизнес
тауэр, 20 давхар

(+976) 7577-0002

info@mongolianre.com

www.mongolianre.com

